



СЭЛЭНГЭ АЙМАГ
ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/ 126

Нарт

ТӨСВИЙН ЗАРДЛЫН БҮЛЭГ ХООРОНД
ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ТУХАЙ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 "г" заалт, Сангийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төсвийн орлогын сар улирлын хуваарийг 1 дүгээр хавсралтаар, сумын төрийн санд харьяалагддаг орон нутгийн төсвийн байгууллагуудын сар улирлын хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Сумын төсвийн орлогыг батлагдсан хуваарийн дагуу бүрдүүлж ажиллахыг Татварын улсын байцаагч /М.Ганцолмон/, төсөвт байгууллагуудын зардалыг холбогдох заавар журмыг үндэслэн хуваарийн дагуу санхүүжүүлэх, төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн сарын мэдээ, нэгдсэн тайланг хуульд заасан хугацаанд гаргаж тайлагнахыг Санхүүгийн албаны дарга /Б.Оюун-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын дарга /Ш.Гачимэг/-т даалгасугай.

ДАРГА

Г.БАТ-ОРХОН

